

## «Шинэ толь хэмээх бичиг» бол чөлөт хэвлэл мөн

Н. Пүрэвсүрэн\*

\* «Зохиомж» дээд сургуулийн багш, магистрант

«Шинэ толь хэмээх бичиг» сонин нь Монголын ард түмэн Манж Чин гүрний ноёрхлоос ангижран тусгаарласнаа тунхаглаж Богд хаант улс байгуулагдсаны дараа Ж.Цэвээн, тэргүүтэй Монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үзэл санааны туг болсон соён гэгээрүүлэгч сэхээтнүүдийн санаачлан гаргасан анхны тогтмол хэвлэл юм.

Энэ сонины эхний дугаар нь олноо өргөгдсөний гуравдугаар оны хоёрдугаар сарын 12 буюу аргын 1913 оны 3 сарын 6-нд, эцсийн 20 дахь дугаар нь 1919 оны 8 сарын 21-нд гарчээ. Тухайн цаг үеийнхээ Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний үзэл санааны индэр болж байсан энэхүү сонин ард түмнийг соён гэгээрүүлэх, шинжлэх ухааны анхны мэдэгдэхүүнтэй танилцуулахыг тэргүүн зэргийн зорилго болгож байжээ.

Тийм ч учраас сэтгүүлийг гаргагч нь эхнийхээ дугаарт сонины зорилгыг тодорхойлохдоо «Өдгөө олон монголчууд нэгэнт тулгуур төр байгуулж тусгаар улс болсноос хойш зүй нь аливаа эрдэмд боловсорч яаравчлан хүчтэй чийрэг бо-

лохыг хичээвээс зохих тул манай бичгийн хэвлэлийн хороо гадаад олон улсын хэрэглэж ахуй зүйл бүрийн эрдмийг товчлон бичиж, дэвтэр байгуулан дармал болгомуй» хэмээн онцлон тэмдэглэжээ.

Энэхүү сонинд эрхлэн гаргагч Ж.Цэвээн, Д.Бадрахбаатар, Н.Жанцансамбуу, нар ажиллаж байв.

Энэхүү сонины нийтлэлд академич Б.Ренчин, Ш.Нацагдорж нар болон судлаач Т.Содномдаржаа «Монгол ном хэвлэлийн хураангуй түүх» (УБ. 1965), А.Дашням «Монгол оронд хэвлэл үүсч хөгжсөн түүхээс» (УБ. 1962), доктор М.Зулькафиль «Орчин үеийн сэтгүүл зүй» (УБ. 1998), доктор Г.Дэлэг «Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл» (УБ. 1965), дэд доктор Л.Норовсүрэн «Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм» (УБ. 2000) зэрэг бүтээлээрээ задлан шинжилгээ хийж сонины сэдэв, агуулга чиглэлийг тодорхойлсон бол дэд доктор Ч.Чойсамба «Монгол сонины мэдээ» (УБ. 2000) нэг сэдэвт зохиолдоо тус сонины мэдээний онцлог, хэл найруулга, төлөв байдлыг тодорхойлсон байна. «Шинэ толь хэмээх бичиг» нь Монголын үндэсний сэтгүүл зүйн

эх суурийг тавьсан гэдэг утгаараа сэтгүүл зүйн судалгааны анхдагч судлагдахуун байсаар ирсэн билээ. Тийм ч учраас сэтгүүл зүйн судлал, шүүмжлэлийн асуудал ч энэхүү сониноос эхлэлтэй тул дээрх эрдэмтэн багш нар, судлаачид тус сониныг судалсаар ирсэн билээ.

Түүнчлэн тус сониныг эрхлэн гаргагч Ж.Цэвээн, Д.Бодоо, Д.Бадрахбаатар нарыг судлах явцад ч тэдний амьдрал, үйлстэй салшгүй холбоотой байсан энэхүү сонины тухай дурдагддаг юм. Ялангуяа дорно дахины судлаач нэрт эрдэмтэн, сэт-

гүүлч, соён гэгээрүүлэгч Ж.Цэвээний мэндэлсний 80, 100 (1961, 1981) жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурал дээр түүний эрхлэн гаргаж байсан энэхүү сонины тухай

буюу Монголын оюуны соёлын түүхэнд оруулсан үнэтэй хувь нэмрийг нь цохон тэмдэглэсэн байдаг. Мөн тус сонинд өгүүлэл нийтлэлээ бичдэг байсан Финляндын нэртэй монголч эрдэмтэн Рамштед нарын зэрэг эрдэмтдийн амьдрал үйл хэрэгтэй салшгүй холбоотой энэхүү сонин зөвхөн Монголд төдийгүй, Финлянд, Буриад, ОХУ зэрэг гадаад улс орнуудад судлагдсаар ирсэн юм.

**М**иний бие тус сонины 20 дугаарыг кирилл бичигт хөрвүүлснээр Монголын сэтгүүл зүйн эх суурийг тавьсан

гэж ярьдаг «Шинэ толь хэмээх бичиг» нь чухам ямар хэл найруулгаар бичигдэж байсан хийгээд, нийтлэлтэй нь бүрэн эхээр нь уншиж, танилцах боломж бололцоог сэтгүүл зүйн ангийн оюутнуудад бүрдүүлж өгч байгаагаараа онцлогтой юм. Учир нь оюутнууд судалгааны ажил хийх гэж оролдоогүй л бол үндэсний архивын газарт суух нь ховор байдаг төдийгүй хуучин эхээр нь унших гэхэд одоогоос 90-ээд жилийн өмнөх үг хэллэг, өгүүлбэрийн найруулгыг галиглаж ойлгох томоохон бэрхшээлтэй тулгардаг.

Иймд кириллээр нь уншиж танилцах боломж бүрдсэнээр оюутнууд эртний үг хэллэгийг толь бичгээс харж галиглахгүй цаг хугацаа хожих, улмаар багшийн зааж буй лекц, ном сурах бичигтэй харьцуулан энэ сонины тухай бүрэн төгс мэдлэгтэй болоход тус дэм болох буй за.

Монголын ууган тогтмол хэвлэлийг хэдийгээр Монгол Улсын Гадаад Явдлын Яам, Хаант Оросын элчин Консулын хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр гаргасан боловч, хэрэг дээрээ Монголын дэвшилт сэхээтнүүдийн үзэл санааны индэр болж байжээ. Энэ нь тус сонины хурц дайчин үг хэллэгтэй нийтлэлүүдээс тод ажиглагддаг. «Шинэ толь хэмээх бичиг» улс орныхоо тусгаар тогтнол, эдийн засгийг хөгжүүлэхэд саад болж байгаа аливаа дутагдлыг илчлэн шүүмжилж, ард олныг бичиг эрдэмд сурган гэгээрүүлэх,

«

*Монголын ууган тогтмол хэвлэлийг хэдийгээр Монгол Улсын Гадаад Явдлын Яам, Хаант Оросын элчин Консулын хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр гаргасан боловч, хэрэг дээрээ Монголын дэвшилт сэхээтнүүдийн үзэл санааны индэр болж байжээ.*

»

улс орныхоо хөгжил, цэцэглэлтийн төлөө хөдөлмөрлөхийг уриалж байсан байна.

Түүнчлэн улс орны мандаж хөгжихийн үндэс нь эрдэм боловсрол хэмээн үзээд сургууль бичиг соёлын асуудалд их анхаарч байсан нь «Монгол улсын сургуулийн учир» хэмээх өгүүлэлд «...Сайд Ханддоржийн Оросын нийслэл хотноо элчин болж одсон завсар сургуулийн аль бүхий явдал нь хөнгөн болж, байшин барилгыг засалгүй, багш шавь нарын түлээг тасалдуулж, тэднийг элэглэсэн мэт туйлын муу морьд уяж, хэрэглэлийг хожигдуулан хүлээгдүүлж, зарим шавь нарын хэрэглэлийг тогтоосон хэмжээ тооноос хасагдуулан, өлбөрч өвчин олоход хүргэжээ...» хэмээн бичсэнээс үзэхэд тодорхой байна. Мөн «Монголын баялгийн учир» хэмээх өгүүлэлд «Монгол Улсын орлого зарлагын явдлыг тэнцүүлж бодож үзвэл одоо үед зарлага нь үлэмж давж өр зээл тавьж эхэллээ. Гэтэл Монгол Улсын хөрөнгө, газар дэлхийн баялаг, түүхий эдийг ёсоор ашиглан боловсруулж чадвал жил бүр арван сая цаасны орлог авч болох юм» хэмээгээд ашиг олж болох газрын дээр, доорх баялаг, ургамал, ан гөрөөс, загас зэргийг тоочсон байна. «Шинэ толь хэмээх бичиг» сонины нийтлэлийн сэдвийн хүрээ өргөн, нийтлэгдэж буй материалууд нь цензургүй, бие даасан байдалтай байхын зэрэгцээ хурц дайчин шүүмжлэлүүдээрээ Богд гэгээний засгийн газар, болон нийгэмд хүчтэй цохилт өгдөг байсан байна. Тухайлбал: «Монголчууд ажилд муу» өгүүлэлд «...Монголчууд эрх биш өөрийн биеэр явж ажиллаваас сая тус

гарна, хэмээвч анхнаас сургасаар ирсэн аж төрөх ёсыг өөрчлөн халахуйд тун ч амаргүй тул монголчууд тариан ажилд боловсортлоо хэдэн он өнгөрнө за. Манай монголчуудын аль аль нь ажилгүй, ганцхан чонын "учруулсан" хохирлыг мөнгө цаас болгож бодвоос хэд хэдэн саяд хүрнэ. Сүүлийн үед ард албатын мал нь чонын өршөөл цаазанд итгэх болчихай» хэмээжээ. Мөн Англи, Герман, Швейцари, Франц зэрэг орны хөдөө аж ахуйн ажилчид хүчээ нэгтгэн хоршоо байгуулж, өргөн хэрэглээний зүйлсийг хямд үнээр авч, түүхий эд, бүтээгдэхүүнээ өндөр үнэ хүргэн борлуулж байгаа тухай болон Оросын тариачдын хоршоо хамтралын давуу талыг ухуулан бичсэн байна. Тийм ч учраас Ж.Цэвээн, Д.Бодоотой хамтран хоршооны дүрэм боловсруулж улсын дээд хуралд өргөн барьж байжээ. Түүнчлэн сонинд бүхэлдээ хүн ардыг гэгээрүүлж боловсруулах, танин мэдүүлэх чиглэлийн нийтлэлүүд гарч байсан байна. Тиймээс ч сониныг «Эрдэм сурахад эрхэмлэх дэвтэр» гэж хаягласан ба анхны дугаартаа эрхлэгч Ж.Цэвээн «Элдэв ухааныг боловсруулсан бичиг» гэсэн тэргүүн өгүүлэл бичиж, түүндээ олон монголчуудыг эрдэм сурахад нэмэр болгож нийтлэхээр бэлтгэж байгаа зүйлийнхээ тухай дурджээ. Мөн тус сонинд дан ганц шинжлэх ухааны хоосон номлол гардаггүй, шинжлэх ухааны асуудлыг цаг үе, амьдрал ахуйтайгаа холбон бичиж байсан. Үүний тодорхой жишээ бол «Хар тамхины учир» өгүүлэлд Богд хааны засгийн газар Англиас хар тамхи худалдан авч ашиг олохоор сэдэж буйг буруушаан, түүний хор хөнөөлийг

ойлгуулан жигшүүлэх зорилгоор тайлбар өгүүлэл нийтэлж байжээ.

Мөн «Тэнгэрийн дуу цахилганы учир», «Хүний насны учир» зэрэг цуврал өгүүлэлд «...Манай дэлхий дээр ургамал, адгуусан амьтан, хүн төрөлхтөн эдгээр гурван зүйлийг шим буюу гишүүтэн гэнэ.

Энэ гурван зүйлийн амьдрагчид цөм үржих, өтлөх, үхэхийн жамыг эдэлнэ. Дэлхий дээрх ургамалын төрөл 600 мянган зүйл бөгөөд үүний гурван хувийн 2-ыг хүн тарьж боловсруулна. Адгуусан амьтны төрлийг ялгавал 300 мянган төрлийн ан гөрөөс,

мал буй. Шувууны төрөл түм илүү зүйл, загас 13 мянга илүү зүйл байдаг. Эрвээхэй батгана тэргүүтэн, тасархай биетэн 200 мянга илүү зүйл байна. Дэлхий дээрх хүний тоо 1.720 сая ам бөгөөд торлоор ялгавал цагаан арьстан 876 сая, шар арьстан 680 сая, хүрэн арьстан 36 сая, америкийн улаан 9 сая, африк, австрали тивийн хар арьстан 180 сая бөгөөд эдгээрээс гадна төрөл эх илрэгчид 83 сая байна. Манай монголчууд шар арьстны тоонд багтана» гэх мэтээр сонирхолтой танин мэдүүлэх ач холбогдолтой.

«Шинэ толь хэмээх бичиг» нь Монголын ууган тогтмол хэвлэл, сэтгүүл зүйн эх суурийг тавьсан гэдгээрээ дахин давтагдашгүй ач холбогдолтой билээ. Хэрвээ 1913 оны 3-р сарын 6-нд тус сонин

гараагүй, тухайн үед үүнийг гаргах үндэсний дэвшилт сэхээтнүүд төрөөгүй байсан бол Монголд сэтгүүл зүй үүсэлгүй ардын хувьсгалтай золгож, хувьсгал ялтал 8 жилийн хугацаанд монголчууд дэлхийн соёлоос хоцрогдсоор байх байсан юм.

«Шинэ толь хэмээх бичиг»-т улс

орны тусгаар тогтнолыг хамгаалахтай холбогдсон олон чухал баримт бичгүүд нийтлэгдэж байсан ба энэ нь тус сонины нийтлэлийн гол сэдвийн нэг байжээ. Сонин хятадууд Монголын тусгаар эрхийг эргүүлэн авах бодолтой байхад оросууд бие даасан улс байлгахыг хүсч байгааг мэдээлж, түүний учир нь хятад улс Монго-

лын газар нутгийн баялгийг дураар ашиглаж, зах зээлээ болгох санаатай байна. Харин орос улс өөртөө халхавч болгоход тустай байх бараа таваараа борлуулах зах зээлтэй байхыг хүсч байгааг ард нийтэд тайлбарлан таниулж байв. Мөн 1912 оны 12-р сарын 21-нд байгуулсан Орос-Монголын Найрамдлын гэрээ бичгийг нийтэлжээ. Энд :

1. Их орос улсын хааны засаг, Монгол улсын өөртөө эзэрхэх ёс журмыг сахихад тусална.

2. Оросын худалдааны онц эрхийг хуучин ёсоор хэрэгжүүлнэ.

3. Монгол улс өөр улстай гэрээ тогтоохдоо Оростой урьдчилан зөвлөхгүй боловч энэ дурьдсан зүйлийг харж

«

*Сонин хятадууд монголын тусгаар эрхийг эргүүлэн авах бодолтой байхад оросууд бие даасан улс байлгахыг хүсч байгааг мэдээлж, түүний учир нь хятад улс монголын газар нутгийн баялгийг дураар ашиглаж, зах зээлээ болгох санаатай байна.*

»

өөрчлөхгүй хэмээсэн 3 заалт орсон байжээ.

Найрамдлын энэ гэрээг нийтэлсэн нь санамсаргүй хэрэг биш, үүнийг ард түмэнд ойлгуулан хүргэх, гэрээний хэргэжилтэнд хяналт тавиулах гэсэн санаа байв. Сонинд хүн ардыг танин мэдүүлэн боловсруулах, нийтлэл гарч байсан байна.

«Шинэ толь хэмээх бичиг» нь өнөөдөр Монголын сэтгүүл зүйн тэр тусмаа чөлөөт сэтгүүл зүйн эх суурийг тавьсан гэдгээрээ төдийгүй тус сонин нийтлэл, мэдээ мэдээлэл болон тухайн цаг үеийн улс орны амьдралын ороо бусгаа байдал, зохиогчидтой холбоотой олон баримт сэлтийн гэрч нь болж, архивын чухал материал болон ашиглагдаж байгаа юм.

❖ Түүнчлэн «Шинэ толь хэмээх бичиг» сонин нь баруун европын болон дэлхий дахины шинжлэх ухааны нээлт, ололт амжилтыг монголчуудад сурталчилсан анхны хэвлэл юм.

❖ Тус сонин Монголын хамгийн анхны танин мэдүүлж, соён гэгээрүүлэгч сонин байсан.

❖ Монгол улс, Монголын ард түмний тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлж, эрх чөлөөний төлөөх тэмцэлд эв хүчийг эвлэлдүүлэн нэгтгэхэд онцгой чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

❖ Монгол улсад шинэ эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө суртал-

чилгаа, ухуулга явуулж, аж ахуй, эдийн засгийн сэдэвт нийтлэлүүдээрээ нийгмийн бүтээн байгуулалтад зохион байгуулагч үүрэг гүйцэтгэж байсан.

❖ Тус сонин

ны хоёр дугаар тутмын нэгэнд шүүмжлэлт материал нийтлэгдэж, нийгмийн хөгжилд саад тотгор болж буй бүхнийг шүүмжилдэг байсан байна.

❖ «Шинэ толь хэмээх бичиг» сонин нь

«

*Тус сонинд мэдээ мэдээлэл, сурвалжлага, тайлбар өгүүлэл ярилцлагын шинжтэй мэдээ мэдээлэл, шүүмжлэлт өгүүлэл зэрэг сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлүүд нийтлэгдэж байсныг үзвэл сонинд ажиллагсад нь бичиг боловсролын өндөр ур чадвартай байсныг харуулж байна.*

»

«Ертөнцийн байдал төлөвөөс», «Дэлхий дээрх хүмүүсийн аж төрөхүйн учир», «Хүний насны учир», «Болгар, Хятад, Япон улсын тухай», «Хар тамхины учир», «Монголын баялгийн учир», «Хөх Монголын хөх туг» роман, «Уйгар улсын хураангуй түүх» зэрэг түүхэн чухал баримт бичгүүдийг нийтэлж байснаараа Монголын ард түмний үндэсний ухамсрыг сэргээн бадруулж, улс эх орныхоо түүх соёлоор бахархах сэтгэлийг ард түмэнд төрүүлж, нүүдэлчдийн утга соёлын нандин дээж бичгүүдийг ард түмний хүртээл болгож байсан түүхэн ач холбогдолтой юм.

❖ Тус сонинд мэдээ мэдээлэл, сурвалжлага, тайлбар өгүүлэл ярилцлагын шинжтэй мэдээ мэдээлэл, шүүмжлэлт өгүүлэл зэрэг сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйлүүд нийтлэгдэж байсныг үзвэл сонинд ажиллагсад нь бичиг

боловсролын өндөр үр чадвартай байсныг харуулж байна. Энэ утгаар нь авч үзвэл тогтмол хэвлэл-лийн нийтлэлийн хэл найруулгыг төлөвшүүлэхэд нөлөөлсөн анхны сонин гэж үзэх бүрэн үндэслэлтэй юм.

Тус сонины хэвлэлийн барыг Ж.Цэвээн өөрийн мөнгөөр хаант Оросоос худалддан авчирсан бөгөөд Монголд гарсан хамгийн анхны хувийн бие даасан сонин байсан юм. Тийм ч учраас ноёд түшмэд, төр засгийн хүнд сурталтнуудийг шүүмжилж чадаж байснаараа ард олны улс төрийн идэвхийг сэргээж тэдний зүгээс төр засгийн үйл ажиллагаанд хяналт тавих, шахалт шаардлагыг хүчтэй болгож байжээ.

Сонины эрдэм шинжилгээний өгүүлэл, томоохон нийтлэл, орчуулгын зохиолыг зохиолч Ж.Цэвээн, аж ахуй, соёлын сэдэвтэй шүүмжлэлт өгүүллүүдийг Д.Бодоо, засгийн газрын мэдээ, сонсгол, тусгаар тогтнол, ардчиллын сэдэвтэй материалыг Д.Бадрахбаатар, цаг үеийн товч, шуурхай сонсгол мэдээнүүдийг Н.Жанцансамбуу нар гол төлөв бичиж байжээ. «Шинэ толь хэмээх бичиг»-ийн нийтлэлүүдээс тусгаар улс байгуулахын төлөө тэмцсэн томоохон нийтлэл нь «Дөрвөн замын уулзвар» хэмээх нийтлэл юм. Эл нийтлэл нь Богдын засгийн газар, Хилийн чанадах түншүүдийн таалалд огт нийцээгүй байснаас болж эрхлэгч Ж.Цэвээнийг 1914 онд Хиагтад гурван улсын хэлэлцээрт оруулах нэрээр аваачиж тэр хойгуур нь тус сониныг хаасан бололтой. 1914 оны сүүлчийн 20 дахь дугаартаа «Дараа юу болохыг хойд хуудсанд үзээрэй» гээд «Цахилгаан

мэдээ» гэж гарчигласан мөртлөө дугуу орхисон байгаа нь доктор Г.Дэлэгийн энэхүү таамаглал үнэний ортой ч байж болох талтай.

1913 он бол монголчуудын хувьд хүнд хэцүү үе байсан боловч тухайн цаг үеийн дэвшилтэт сэхээтнүүд өөрсдийн хөрөнгө, идэвх санаачилгаар сонин гаргаж, төр засгийн үйл хэргийг хурц дайчин шүүмжилж байснаараа үндэсний сэхээтнүүдийн үзэл санаа бүрэлдэн төлөвшихөд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

«Шинэ толь хэмээх бичиг» сонин сайд ноёдыг ил шүүмжилж алдар нэр, албан тушаал, хэргэм цолоор нь тодорхой хаягтай шүүмжилж болохгүй байсан тэр үед гадны дарамт хавчлага мөрдөлт мөшгөлтөөс айлгүй, шулуун шударга зүйлийг нийтэлдэг байсан нь түүний чөлөөт хэвлэл болохыг харуулж байгаа юм.

«Шинэ толь хэмээх бичиг»-ийг чөлөөт хэвлэлд тавьдаг өнөөгийн есөн шалгуураар шинжвэл статусын хувьд бүрэн бие даасан, төр засгийн бодлогоос ангид зүйл нийтэлдэг. Ил тод шулуун шударга нийтлэлтэй, нийгэм улс төрийн нийтлэг хэвлэлийн тодорхой хүрээнд үйлчилдэг, ямар ч цензургүй, сайд ноёдыг засаг төрийн хэрэгт хяналт тавих замаар сөрөг хүчний үүрэг гүйцэтгэж чадаж байсан зэрэг шинжээрээ Монголд гарсан хамгийн анхны хувийн бие даасан чөлөөт хэвлэл мөн.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. "Шинэ толь хэмээх бичиг" сонин. 1913. № 1-20.

2. Дэлэг Г. 1965. Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.
3. Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. УБ.
4. Зулькафиль М. 1998. Орчин үеийн сэтгүүл зүй. УБ.
5. Чойсамба Ч. 2000. Монгол сонины мэдээ. УБ.
6. Зулькафиль М., Чойсамба Ч. 2001. Чөлөөт хэвлэл өчигдөр, өнөөдөр, маргааш. УБ.
7. Дашням А. 1962. Монгол оронд хэвлэл үүсч хөгжсөн түүхээс. УБ.
8. Баасансүрэн Т. 2002. Сэтгүүлчийн ур чадварын асуудал уламжлал ба шинэчлэл. УБ.
9. Пүрэвсүрэн Н. 2002. "Шинэ толь хэмээх бичиг" сонины нийтлэл, түүний онцлог шинж" дипломын ажил. УБ.

### **The Newspaper "Shine Toli Khemeekh Bichig" as a Free Press**

"Shine toli khemeekh bichig" free press" newspaper 9 criterion in recent free press indications:

- It becomes completely independent
- Publishes non-independent material from the state policy
- Has a dissemination with openness and honest dissemination
- Service definite frame of press
- Hasn't any censor
- Put the control of states and minister and lord could fulfill duties of opposition force
- These appearances confirm it, Mongolian first private independent free press.

The literary monument "Shine toli khemeekh bichig" put the foundation of Mongolian journalism and the free press. It has the following feature:

The "New dictionary and script" dissemination news and information are being used the important material of archives and became witness of fact that connected with the writers and journalists and state's living rough time at an every occasion.